БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС "ЭРДЭНЭМАНДАЛ СУРГУУЛИЙН БАРУУН ТАЛЫН 4 ЗАМЫН УУЛЗВАРТ ИЖ БҮРЭН ГЭРЛЭН ДОХИО СУУРИЛУУЛАХ" АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2026 оны 01 дүгээр сарын 21 Номгон

Авто замын гэрлэн дохио, техникийн шаардлага MNS 4980:2014 стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Мөн цахилгаан шугам сувагчлал, монтаж хийхдээ цахилгаан эрчим хүчний холбогдох хууль, дүрэм журам, стандарт, ажлын зураг төсвийг баримталж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь хийж гүйцэтгэж буй ажлын явцыг захиалагчид мэдэгдэн шалгуулах, ил далд ажлын акт үйлдэх.

Гүйцэтгэлийн тайланд ажил тус бүрийг он сартай хөндлөн фото зургаар баталгаажуулж гүйцэтгэлийн тайланд хавсаргана. Аль нэг зураг авалт хийгдээгүй тохиолдолд тухайн ажлыг гүйцэтгээгүйд тооцно.

Далд ажлыг хийхийн өмнө захиалагч байгууллагт мэдэгдэж бэлэн байдлыг шалгуулах. Сувагчлал, цахилгааны кабель гэх мэт ажилд далд ажлын акт үйлдэж баталгаажуулснаар тухайн ажлыг эхлүүлнэ.

<u>Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирүүлэх материал:</u>

- Гэрлэн дохио суурилуулах, тоноглох, ажил гүйцэтгэх үе шатны график
- Инженер техникийн ажилчдын мэдээлэл

№	Албан тушаал	Тоо	Ажлын туршлага /жил/
1	2	3	4
1	Авто замын инженер	1	2 болон түүнээс дээш /үндсэн/
2	Цахилгааны инженер	1	2 болон түүнээс дээш /гэрээт байж болно/
3	Хөдөлмөр хамгааллын инженер	1	2 болон түүнээс дээш /гэрээт байж болно/

Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

<u>Гэрлэн дохио тоноглолын ажил:</u>

Эрдэнэмандал сургуулийн баруун талын 4 замын уулзварт гэрлэн дохио суурилуулах бөгөөд. Дараах ажил хийж гүйцэтгэнэ Үүнд:

- Гэрлэн дохио /Т.2.а/- 4ш
- Явган хүний гэрлэн дохио /Я.1/-8ш
- Төв замын гэрлэн дохионы секунд тоологч 4ш
- Явган хүний гэрлэн дохионы секунд тоологч-8ш
- Контроллер /22 гаралттай/-1ш
- Тоон удирдлагын дэлгэц 400х400мм-4ш
- Дуут дохио-8ш
- Өндрийн шон /8м, Ф219мм/-4ш
- Өндрийн шонгийн бетон суурь /1200*600*600мм/-4ш
- Нам шон /3.5м,Ф120мм/-4ш

- Нам шонгийн бетон суурь /800*400*400мм/-4ш
- Хуванцар даацын хоолой Ф50мм-50м
- Кабель КВВГ4х2.5мм-580м
- Кабель КВВГ2х10мм-50м
- Хамгаалалтын тууз-170м
- Нэг туйлт автомат /16А/-1ш
- 1 фазын ухаалаг тоолуур-1ш
- Тоолуурын хайрцаг/IP-54/-1ш -/40х1,2х60/

Анхаарах зүйлс:

Гэрлэн дохионы кабель нь 4 буюу түүнээс дээш жийлтэй, 2.5мм голчтой цул зэсээр хийгдсэн, гадна талбайд татагдах зориулалттын бүрээстэй кабель байна.

Явган зорчигчийн гэрлэн дохионы кабель нь 3 буюу түүнээс дээш жийлтэй, 2.5мм голчтой цул зэсээр хийгдсэн, гадна талбайд татагдах зориулалттын бүрээстэй кабель байна.

Цахилгаан эх үүсвэрт гэрлэн дохио холбох ажлыг "Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК олгосон техникийн нөхцөлийг дагуу хийж гүйцэтгэнэ.

Цахилгааны эх үүсвэрээс гэрлэн дохионы контроллер хүртэл татагдах тэжээлийн кабель нь 4-10мм-с багаггүй голчтой, цул зэс эсвэл хөнгөн цагаан гадна талбайд татагдах зориулалттын бүрээстэй кабель байна.

Бүх кабель ямар дундаа залгаа байхгүй өмнө ашиглаж байгаагүй шинэ байна.

Гэрлэн дохио суурилуулах ажлын шаардлагатай бараа материалыг захиалагч байгууллагаар бүрэн бүтэн байдал, шинэ эсэхийг баталгаажуулж ажил гүйцэтгэнэ.

Ажлын үе шат бүрийг 1 байрлалаас 3-с доошгүй он сартай, хөндлөн авсан зургаар баталгаажуулна. А4 хуудсанд өмнө дараа гэх харьцуулалтаар нийт 6ш, зураг тус бүрийг ажлын үйл явцыг тодорхойлсон тайлбартайгаар эвлүүлнэ.

Ажлын гүйцэтгэлд бичмэл тайлан, үе шатны зураг авалт, ил далд ажлын акт хамаарна. Дээрх бичиг баримтаас аль 1 нь дутуу, захиалагчийн шаардлагад нийцэхгүй тохиолдолд хүлээн авахаас татгалзана.

Гүйцэтгэсэн ажлын чанарын шаардлага хангалтгүй мөн ашиглаж буй бараа, тоноглолын ажлын материал нь зураг төсөвт нийцэхгүй тохиолдолд ажлыг шинээр хийлгэх, солих, дахин тоноглолын ажил хийж гүйцэтгүүлнэ. Дээрх ажилбараас шалгаалж гарсан нийт зардлыг гүйцэтгэгч өөрөө бүрэн хариуцна.

Гүйцэтгэгч нь Авто замын гэрлэн дохио, техникийн шаардлага MNS 4980:2014 стандартын бүх шаардлагад нийцүүлж ажиллана.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол улсын Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйлийн **28.4-т "Шинээр барьж байгуулсан авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаа нь**

гүйцэтгэгч болон техник, технологийн хяналт тавьсан хуулийн этгээдэд тус бүр гурван жил байна гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Гэрлэн дохио суурилуулах ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс ажлын 5 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ. Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

ХЯНАСАН:
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.ЭНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ц.БАЯНБАТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН
"БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ"
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИ
9-р дүгээр байр, Тэвэрчдийн гудамж 3,
Баянмөнгөн 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг 64101, Утас: (976) 70442356
Цахим шуудан: energybhr@gmail.com

2025.12.08 № 348

танай 2025.12.03-ны № 35/375-т

"ГЕО УРБАН КОНСАЛТИНГ"
ХХК-Д

Мэдээлэл хүргүүлэх тухай

Эрдэнэмандал сургуулийн баруун талын 4 замын уулзварт суурьлуулах иж бүрэн гэрлэн дохионы цахилгаан тэжээл татах холболтын цэгийн мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.УЛАМБАЯР

642505090

D:\АЛБАН ТООТ 2025\А4 тоот.docx


Тогтолтийн тулбуураас хаалт гараж
Эхлэл шугам
Эхлэл шугам
Description
Icon
Icon size
Medium (
More settings
Labels
Label size
Medium (default)
Placemark placement
Latitude
46.1916962
Longitude
100.7117816
Altitude
1.5743617075
Grounding
Done
Saved to Googl
3D